

ХӨГЖИЛ ФИНАНС ББСБ-ЫН АУДИТ, ЭРСДЛИЙН ХОРООНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Хөгжил Финанс ББСБ (цаашид “ББСБ” гэх)-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудит Эрсдлийн Хорооны бүрэлдэхүүн, дарга, гишүүдэд тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж Аудит Эрсдлийн Хорооны үйл ажиллагаа (цаашид “АЭХ” гэх)-тай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн засаглалын баримт бичиг, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох заавар, журам, эрх зүйн бусад акт дүрэмд нийцсэн байна.
- 1.3. Хөгжил Финанс ББСБ -ын Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх АЭХ нь Санхүүгийн зохицуулах хорооны баталсан “**Компанийн засаглалын кодекс**”-ийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.
- 1.4. АЭХ нь компанийн ТУЗ д дараахи асуудлуудаар дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдана:
 - Компанийн гүйцэтгэх удирдлага нь

ХОЁР. АУДИТ, ЭРСДЛИЙН ХОРООНЫ ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1 АЭХ-ны дарга, гишүүд нь санхүүгийн тайлагналын зохих мэдлэг, туршлагатай байна;
- 2.2 АЭХ-ны дарга нь компанийн хөндлөнгийн аудитортой аливаа холбоогүй, сүүлийн гурван жилийн хугацаанд тухайн хөндлөнгийн аудитын компанид ажиллаж байгаагүй байна;
- 2.3 АЭХ-ны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна;
- 2.4 АЭХ нь гураваас доошгүй гишүүнтэй байна.
- 2.5 АЭХ нь гишүүдийн дийлэнх олонх хараат бус гишүүнтэй байхыг зорино.

ГУРАВ. АУДИТ ЭРСДЛИЙН ХОРООНЫ ҮҮРЭГ

- 3.1. Компанийн санхүүгийн мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- 3.2. Компанийн санхүүгийн тайлагналын систем, дотоод хяналтын үйл явц, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хяналт тавих;
- 3.3. Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
- 3.4. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;

- 3.5. Дотоод аудитийн шалгалтын улирал, жилийн тайланг хэлэлцэж, санал дүгнэлтээ ТУЗ-д танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах;
- 3.6. Дотоод аудитор, эрсдэлийн чиглэлээр заавар зөвлөмж өгөх, чиглүүлэх;

ДӨРӨВ. АУДИТ, ЭРСДЭЛИЙН ХОРООНЫ ЭРХ

- 4.1. Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал гаргах;
- 4.2. Компанийн эрсдлийн үйл ажиллагааны тайлантай танилцах, нягтлах, шаардлагатай тохиолдолд ТУЗ-д танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулах;
- 4.3. СЗХ, Татвар, Нийгмийн даатгалын байгууллагын шалгалтын акттай танилцаж, нягтлах, холбогдох арга хэмжээг авах;
- 4.4. Дотоод аудитын аутсорсинг компанитай хамтран ажиллах, үйлчилгээний зардлыг жилийн төсөв, төлөвлөгөөнд тусгуулах саналыг ТУЗ-д танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулах;
- 4.5. Компаний үйл ажиллагааны зохистой харьцаа, өмч хөрөнгө, ашигт ажиллагаа, орлого, зардал, зээлийн багцын чанар, эрсдлийн сангуудыг хянаж шалгах;
- 4.6. Компаний Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг хянах;
- 4.7.

ТАВ. АУДИТ ЭРСДЛИЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХАРИУЦЛАГА

- 5.1. АЭХ компанийн санхүүгийн тайлагнал, Хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан шийдвэр, ТУЗ-ийн тогтоолын гүйцэтгэлийг жилд нэгээс доошгүй удаа шалгаж хянана.
- 5.2. АЭХ нь компанийн аудитын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайлагналын чанарыг хангана;
- 5.3. АЭХ нь компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг тогтмол хянаж, эрсдэлийг хянах, илрүүлэх дотоод хяналтын тогтолцооны үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна;
- 5.4. Компанид тулгарч байгаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн удирдаж байгаа талаар бүрэн гүйцэд мэдээллийг Гүйцэтгэх удирдлагаас хагас, бүтэн жилээр тогтмол авч хэлэлцэн заавар, удирдамж өгнө;
- 5.5. АЭХ нь компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, журам, хэрэгжилтийн талаарх мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүй тайлбарлана.
- 5.6. АЭХ нь Хөндлөнгийн аудитыг сонгохдоо банк санхүүгийн байгууллагад аудит хийх эрх бүхий мэргэжлийн, тусгай зөвшөөрөлтэй байдлыг харгалзана;
- 5.7. Хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангана;

- 5.8. АЭХ, Гүйцэтгэх удирдлага, Хөндлөнгийн аудиторын хооронд тогтмол мэдээлэл солилцоход компаний ерөнхий нягтлан бодогч, эрсдлийн ажилтан нартай харьцана;
- 5.9. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгч болно;